
Төв аймаг дахь Төрийн аудитын газрын өөрийн санаачлагаар 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

**СХС-гаас олгосон зээлийн төлөлт хугацаа хэтэрч,
ашиглалт, үр дүн хангалтгүй байна.**

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ, ҮР ДҮН



АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгсийн тайлбар	3
Төв аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Асуудал 1	
Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал	СХС-д төвлөрөх ММСС-ийн худгийн үнэ 138.1 сая төгрөг, зээлийн хүүг дутуу тооцсон 84.2 сая төгрөг, нийт 222.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	6
Аудитын менежер О.Амаржаргал	Асуудал 2	
Ахлах аудитор Т.Майцэцэг Ц.Базарсад Аудитор Ц.Саранчимэг О.Сосор А.Батлхагва Ж.Бямбацогт	Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төслийг СХСХБЗТХТЖ-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг хянаагүй байна.	11
	Асуудал 3	
	СХС-гийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалт үр дүн муутай байна.	22
2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр	Дүгнэлт	26
	Зөвлөмж	27
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Холбогдох байгууллагын санал	28
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70272463 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу		
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын 2-р ордон		

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ММСС	Монголын мянганы сорилтын сан
ХОБТ	Хот орчмын бэлчээрийн төсөл
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
СХСХБЗТХТЖ	Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах, хяналт тавих журам
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХЭДЗ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Зөвлөл

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Төв аймаг дахь Төрийн Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаныг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Төв аймгийн хэмжээнд Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт , үр дүн, үйл ажиллагааг шалган дүгнэлт, зөвлөмж, боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Үүнд :

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зохих журмын дагуу бүрдүүлж байна уу?
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг журмын дагуу сонгон шалгаруулж, зарцуулж тайлагнасан байна уу?
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр бий болсон ажлын байр болон төслийн хэрэгжилтэнд хяналтшалгалт хийгдсэн байна уу?

Аудитаар Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Заамар, Цээл, Угтаал, Батсүмбэр, Борнуур, Сүмбэр, Жаргалант сумдад ажиллаж сум хөгжүүлэх сангийн зээлийн зориулалт, ашиглалт, зээлийг хугацаанд нь барагдуулсан байдал зэргийг шалгасан. Зуунмод сумаас бусад сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн баримт, хувийн хэрэг, анхан шатны баримт, аудитын явцад сумдаас ирүүлсэн сум хөгжүүлэх сангийн зээлийн 2014-2017 оны эхний 9 сарын байдлаарх авлагын судалгаа, сум хөгжүүлэх сангаас зээл авснаар шинээр бий болгосон ажлын байрны судалгаа болон бусад холбогдох баримт материалд тулгуурлан аудит хийв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, АДБОУС 4100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав. Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- УИХ-ын 2015 оны "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай" тогтоол
- МУЗГ-ын 2016 оны 153 тоот тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"

- МУЗГ-ын 2015 оны 396 тоот тогтоолоор батлагдсан "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги батлах тухай" тогтоол
- МУЗГ-ын 2014 оны 278 тоот тогтоолоор батлагдсан "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр (2014-2016)"
- Аймаг, сумын Засаг даргын захирамжууд 2013-2017 он
- Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол бусад холбогдох шийдвэр

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Майцэцэг, аудитор Ц.Базарсад, О.Сосор, Ц.Саранчимэг, А.Батлхагва, Ж.Бямбацогт нар 2016 оны 9-р сарын 19-нээс 10-р сарын 25-ныг дуустал хугацаанд хийж гүйцэтгэв.

Асуудал 1

СХС-д төвлөрөх ММСС-ийн худгийн үнэ 138.1 сая төгрөг, зээлийн хүүг дутуу тооцсон 84.2 сая төгрөг, нийт 222.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна


Улсын төсвөөс 2014 онд СХСанд 676.0 сая төгрөг хувиарласанаас хойш дахин эх үүсвэр хувиарлагдаагүй байна

Сум орон нутгийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор, 2016 оны 153 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг зохицуулах журам батлагдсан байна.

2014 онд улсын төсвөөс 676.0 сая төгрөгийг “Сум хөгжүүлэх санд” татан төвлөрүүлж 27 суманд хүн ам, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх эдийн засгийн боломжит нөхцөл байдлаас хамааруулж 18.0-аас 106.0 сая хүртэлх төгрөгийг хуваарилсан байна.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн түрээс /лизинг/-ээр үйлдвэрийн тоног төхөөрөмжийг авч ашиглахад дэмжлэг үзүүлэхээр Хөдөлмөрийн яамнаас 2014 онд 12 суманд 231.0 сая төгрөгийн санхүүжилт хуваарилагдсан байна.

2015-2017 оны 3-р улирлын байдлаар улсын төсвөөс нэмэлт эх үүсвэр хувиарлагдаагүй байна.



ММСС-ийн хэрэгжсэн төслийн үр дүнгээс эргэн төлөгдөх графикийн дагуу 180.6 сая төгрөг сум хөгжүүлэх санд төвлөрөхөөс 42.5 сая төгрөг төлөгдөж, 138.1 сая төгрөг төлөгдөөгүй байна.

Монголын Мянганы Сорилтын Сангийн "Хот орчмын бэлчээрийн төсөл" нь 2012-2013 оноос эхлэн хэрэгжиж нэг малчдын бүлэгт хөрөнгө оруулалтын гэрээгээр гүн өрмийн худгийн үнийн 50 хувийг, малын хашаа хорооны материалын 100 хувийг, малын тэжээлийн ургамлын үрийн үнийн дүнгийн 25 хувийг 15 жилийн

хугацаанд гэрээний дагуу өөрийн сумын “Сум хөгжүүлэх сан”-д хүүгүйгээр төлөх төсөл хэрэгжсэн байна.



ММСС-ийн ХОБТ-ийн малчдын бүлэгт оруулсан хөрөнгө оруулалтаар аймгийн 13 суманд 69 худаг гаргаж, эргэн төлөгдөх гэрээний дагуу 501.6 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр сумдын Засаг дарга, төрийн сангийн төлөөлөгч, малчдын бүлэгтэй гэрээг хийсэн байна.

№	Сумдын нэр	худаг	Гэрээний тоо	Эргэн төлөгдөх гэрээний дүн	графикийн дагуу төлбөл зохих	төлөгдсөн	төлөгдөөгүй дүн	Мян.төг Санхүүгийн тайланд тусгагдаагүй авлагын дүн
1	Алтанбулаг	6	6	43446.4	15640.7	2090.2	13550.5	41356.2
2	Аргалант	6	8	44683.1	16085.9	3162.6	12923.3	
3	Архуст	4	4	28295.0	10186.2	1556.0	8630.2	26739.0
4	Батсүмбэр	3	4	24090.0	8672.4	2761.4	5911.0	21328.6
5	Баян	1	1	7128.0	2566.1	502.0	2064.1	
6	Баяндэлгэр	8	8	57600.0	20736.0	5782.0	14954.0	51818.0
7	Баянжаргалан	2	2	14400.0	5184.0	0.0	5184.0	14400.0
8	Баянцогт	4	4	26428.0	9514.1	5303.2	4210.9	21124.8
9	Баянчандмань	5	5	34970.0	12589.2	985.0	11604.2	33985.0
10	Борнуур	1	2	9600.0	3456.0	0.0	3456.0	9600.0
11	Мөнгөнморьт	7	7	45576.7	16407.6	1122.7	15284.9	
12	Сэргэлэн	11	13	88952.6	32022.9	6475.6	25547.3	
13	Эрдэнэ	11	12	76435.0	27516.6	12730.0	14786.6	63705.0
	Нийт дүн	69	76	501604.8	180577.7	42470.7	138107.0	284056.6

Дээрх судалгаагаар нийт 13 суманд 76 малчдын бүлэгтэй 501.6 сая төгрөгийн гэрээ байгуулан эргэн төлөгдөх графикийн дагуу 180.6 сая төгрөгийн эх үүсвэр сум хөгжүүлэх санд бүрдүүлэхээс 42.5 сая төгрөг төлөгдөж, 138.1 сая төгрөг буюу 76.5 хувийн эх үүсвэрийг хугацаанд нь бүрдүүлж чадаагүй байна.

ММСС-ийн ХОБТ-ийн малчдын бүлэгт оруулсан хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх гэрээний дагуу 9 сумын сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд 284.1 сая төгрөгийн эх үүсвэрийг авлагаар тусгаагүй байна.

Аудитын явцад худгийн эргэн төлөлтийн авлагыг дутуу бүртгэсэн 284.1 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгуулахаар албан шаардлага бичигдлээ.



2014-2017 онуудад 21 сум СХС-ийн зээлийн гэрээнд тусгасаны дагуу хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд алданги огт ногдуулаагүй байна.

төгрөгийн зээл олгож, 494.6 сая төгрөгийн хүүгийн орлого бүртгэж тайлагнасан байна.

СХСХБЗТХТЖ-ын 1.7-д Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй, эсхүл зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж төлүүлнэ. Торгуулийн хувь хэмжээ, нөхцөлийг сумын Засаг дарга, зээлдэгч нарын хооронд байгуулах гэрээнд тусгана гэж заасны дагуу Аргалант, Баян, Баяндэлгэр, Баянхангай, Мөнгөнморьт, Зуунмод сумдаас 30.2 сая төгрөгийн алданги тооцож эх үүсвэрийг бүрдүүлсэн ба бусад 21 сумд алданги тооцоогүй байна.

Дэлгэрхаан, Сүмбэр сум зээлийн гэрээнд төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээлийн үнийн дүнгээс сарын 0.25-0.5 хувийн алданги тооцно гэж гэрээ хийсэн нь банкны зээлийн хүүгээс бага, зээлийн эргэн төлөх хугацааг хэтрүүлэх муу зээлийн хэмжээ нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

СХС-гийн зээл, зээлийн хүүгийн авлагын 49.7 хувь нь хугацаа хэтэрсэн байгаа нь тус сангаас олгосон зээлийн гэрээ, гарфикийн дагуу эргэн төлөлт хийгддэггүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд гэрээний дагуу алданги тооцож бүртгээгүй, төлөлтийг цаг тухайд нь шаардаж төлүүлж байгаагүйтэй холбоотой байна. Тухайлбал:

№	Сумдын нэрс	2017.09.30-ний байдлаарх Авлагын дүн	Хугацаа хэтэрсэн зээл	Авлагад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь	Нийт хугацаа хэтэрсэн авлагад эзлэх хувь
1	Алтанбулаг	285436.6	52186.5	18.3	1.4
2	Аргалант	287350.6	29855	10.4	0.8
3	Архуст	309568.7	126867.8	41.0	3.3
4	Батсүмбэр	256447.1	77010.774	30.0	2.0
5	Баян	252933.2	73737.1	29.2	1.9
6	Баяндэлгэр	246738.1	145477.4	59.0	3.8
7	Баянжаргалан	226693.1	169876.9	74.9	4.5
8	Баянөнжүүл	244419.0	169685.73	69.4	4.5
9	Баянхангай	181600.9	96293.7	53.0	2.5
10	Баянцагаан	206805.3	109715.1	53.1	2.9
11	Баянцогт	271678.6	107707.7	39.6	2.8
12	Баянчандмань	306169.7	112660.1	36.8	3.0
13	Борнуур	245751.1	207226.2	84.3	5.4
14	Бүрэн	298618.2	84576.2	28.3	2.2
15	Дэлгэрхаан	254796.8	163750.56	64.3	4.3
16	Жаргалант	339700.0	174000	51.2	4.6
17	Заамар	302760.0	141424.5	46.7	3.7
18	Лүн	243753.7	53245.375	21.8	1.4
19	Мөнгөнморьт	277408.6	109589.6	39.5	2.9
20	Өндөрширээт	221862.2	85618.6	38.6	2.2
21	Сэргэлэн	287244.4	284871.9	99.2	7.5
22	Сүмбэр	207837.6	200528.9	96.5	5.3
23	Угтаал	269490.8	103082.7	38.3	2.7
24	Цээл	201649.8	180016.83	89.3	4.7
25	Эрдэнэ	274706.8	232485.3	84.6	6.1
26	Эрдэнэсант	242054.4	30472.218	12.6	0.8
27	Зуунмод	910880.0	484203.8	53.2	12.7
	НИЙТ ДҮН	7654355.3	3806166.5	49.7	100.0

Дээрх хүснэгтээс харахад 2017 оны 3-р улирлын байдлаар 7654.4 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэйгээс 49.7 хувь буюу 3806.2 сая төгрөг хугацаа хэтэрсэн байна.

СХС-гийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтрэлтийг нийт авлагын дүнд харьцуулахад Сэргэлэн суманд нийт авлагын 99.2 хувь, Сүмбэр суманд нийт авлагын 96.5 хувь, Цээл суманд нийт авлагын 89.3 хувь, Эрдэнэ суманд нийт авлагын 84.6 хувь, Борнуур суманд нийт авлагын 84.3 хувь нь тус тус эзэлж байгаа нь хамгийн өндөр байна.

Мөн хугацаа хэтэрсэн зээлийн авлагад сумдын эзлэх хувийг харьцуулахад хамгийн өндөр 12.7 хувийг Зуунмод сум, 7.5 хувийг Сэргэлэн сум, 6.1 хувийг Эрдэнэ сумд эзэлж байна.

ММСС-ийн Хот орчмын бэлчээрийн төслийн хүрээнд малчдын бүлэгт оруулсан хөрөнгө оруулалтыг сум хөгжүүлэх санд эргэн төлөх гэрээний 2.4-д “энэхүү гэрээний 2.2-т заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөрийг төлөөгүй, эсхүл зээл төлөх эцсийн хугацаа хэтэрсэн бол зээлийн хугацаанд төлөгдөөгүй үлдэгдэлд сарын 3 хувийн алданги төлнө” гэж заасны дагуу 13 суманд хэрэгжсэн төслөөс төвлөрөх 138.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлд алданги тооцоогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүүг жигд тооцоогүйгээс 84.2 сая төгрөгийг дутуу тооцож тайлагнасан байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4.7-д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэж зээлдэгчийн үүргийг тодорхой тусгаж өгсөн байна.

СХС-гаас олгосон зээлийн хүүг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнахдаа тухайн санхүүгийн жилд зээлийг ашигласан хугацаагаар тооцож хүүгийн орлогыг бүртгэдэггүй, зээлийн гэрээнд заасан хугацаагаар зээл олгохдоо зээлийн хүүг бөөн дүнгээр бүртгэдэг, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл дүнд зээлийн хүү болон алдангийг тооцдоггүй, зээлдэгч бүрт зээлийн карт хөтөлдөггүйгээс өмнө тооцсон зээлийн хүүг дутуу бодож орхигдуулах зэрэг нийтлэг зөрчил байна. Тухайлбал: 3 жилийн хугацаатай зээл олгоход тухайн санхүүгийн жилд 12 сарын хүүгийн орлогыг бүртгэх байтал 36 сарын хүүгийн орлогыг бүртгэдэг.

Аудитын явцад сумдаас ирүүлсэн судалгаа тайланд үндэслэн 2014-2017 онд СХС-гаас олгосон зээлийн хүүгийн тооцооллыг давтан шалгахад 14 суманд 84.2 сая төгрөгийг дутуу тооцсон зөрчил илэрлээ. СХС-гийн зээлийн хүүг дутуу тооцсон 84.2 сая төгрөгийг сумдын СХС-д төвлөрүүлэх, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдлээ.

СХС-ийн зээлийн хүүгийн орлогын тооцоо /мян.төг/

№	Сумдын нэрс	Санхүүгийн тайлангаар	Аудитаар тооцсон	Дутуу
1	Алтанбулаг	31,627.9	37,157.7	5,529.8
2	Аргалант	20,847.1	21,730.5	883.4
3	Батсүмбэр	25,394.0	26,453.9	1,059.9
4	Баянхангай	11,158.1	14,082.1	2,924.0
5	Баянцагаан	16,010.0	18,779.4	2,769.4
6	Баянцогт	10,550.4	15,867.3	5,316.9
7	Дэлгэрхаан	19,533.5	21,765.4	2,231.9
8	Заамар	13,930.0	25,361.4	11,431.4
9	Лүн	24,072.8	24,643.8	570.9
10	Мөнгөнморьт	8,821.2	21,173.6	12,352.4
11	Сэргэлэн	8,087.2	14,100.8	6,013.6
12	Сүмбэр	6,591.4	19,765.0	13,173.6
13	Цээл	10,708.6	25,823.3	15,114.7
14	Эрдэнэсант	22,974.7	27,812.3	4,837.5
	НИЙТ ДҮН	230307.0	314,516.5	84209.5

Цаашид сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн болон нягтлан бодогч нар зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг үнэн зөв, бодитой тооцож, бүртгэл тайланд тусгах мөн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг арилжааны банкны жишгийн дагуу тооцох шаардлагатай байна.

2014-2017 онд олгосон зээлийн дүнд тооцсон хүүгийн орлогын 32.6 хувийг хугацаандаа төвлөрүүлээгүй байна.

2014-2017 онд 7238.8 сая төгрөгийн зээл олгосноос санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан зээлийн хүүгийн орлого 494.6 сая төгрөгийн 67.4 хувь нь буюу 333.2 сая төгрөг хугацаандаа төлөгдсөн байна.

Сумдын санхүүгийн ажилтнууд зээлдэгчийн зээлийн төлбөрийг бүртгэхдээ алданги, хүү, үндсэн зээлээс хасах дараалалаар тооцоог хийдэггүйгээс хүүгийн орлого буурах эрсдлийг бий болгож байна.

Иймд Иргэний хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн тухай хуульд заасны дагуу зээлдэгч зээлийн төлбөрийг эхний ээлжинд бодогдсон зээлийн хүүг бүрэн төлүүлсний дараа зээлийн үндсэн өрийг төлүүлэх талаар зээлийн гэрээнд тусгай байх нь зүйтэй байна.

Зээлийн хүүгийн төвлөрүүлэлтийн байдал /мян.төг/

№	Сумдын нэрс	олгосон зээл		Тооцсон хүү	Төлөгдсөн хүү	Тооцсон хүүгийн дүнд эзлэх хувь
		тоо	дүн			
1	Алтанбулаг	54	432.2	31.6	19.3	61.1
2	Аргалант	95	299	20.8	25.1	
3	Архуст	156	429.4	27.2	23.1	85.0
4	Батсүмбэр	26	453.5	25.4	23.6	93.1
5	Баян	43	389.6	23.0	17.0	73.8
6	Баяндэлгэр	212	475.6	14.3	8.9	62.7
7	Баянжаргалан	15	161	16.4	10.3	62.6
8	Баянөнжүүл	22	150	10.7	11.2	
9	Баянхангай	35	202.1	11.2	13.6	
10	Баянцагаан	84	209.9	16.0	8.8	54.7
11	Баянцогт	62	236.8	10.6	12.0	
12	Баянчандмань	34	350.8	13.3	16.5	
13	Борнуур	86	167.1	6.1	4.9	81.8
14	Бүрэн	69	335.2	19.4	21.6	
15	Дэлгэрхаан	8	88.2	19.5	10.2	52.5
16	Жаргалант	85	427.8	29.4	28.0	95.0
17	Заамар	92	347.2	13.9	15.2	
18	Лүн	29	194	24.1	9.0	37.3
19	Мөнгөнморьт	49	197.9	8.8	0.0	0.0
20	Өндөрширээт	34	222.4	23.2	14.9	64.2
21	Сэргэлэн	20	171.9	8.1	9.4	
22	Сүмбэр	16	51.8	6.6	0.6	8.5
23	Угтаал	29	157.2	15.2	6.4	42.1
24	Цээл	29	142.8	10.7	2.9	26.7
25	Эрдэнэ	91	337.4	20.5	0.4	1.8
26	Эрдэнэсант	31	241.5	23.0	19.5	85.0
27	Зуунмод	65	366.5	45.7	0.7	1.5
	Дүн	1571.0	7238.8	494.6	333.2	67.4

Дээрх хүснэгтээс харахад 2014-2017 онд олгосон зээлэнд тооцсон хүүгийн орлогыг Аргалант, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Бүрэн Заамар, Сэргэлэн зэрэг сумд бүрэн төвлөрүүлсэн ч Мөнгөнморьт сум огт төвлөрүүлээгүй, Эрдэнэ, Зуунмод, Сүмбэр зэрэг сум нь дөнгөж 1.5-8.5%, Цээл, Угтаал, Лүн зэрэг сумд 26.7%-42.1% төвлөрүүлж зээлийн хүүгийн орлогыг төвлөрүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.

Асуудал 2

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төслийг СХСХБЗТХТЖ-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг хянаагүй байна.

2017 оны эхний 9 сарын байдлаар нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 7 суманд харьцангуй багаар буюу 5.0-8.0 сая төгрөг олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3.1-д заасны дагуу сумдын ИТХ-аар сум хөгжүүлэх сангийн төсвийг 2016 оноос эхлэн батлуулан ажиллаж байна.

2017 оны СХС-ийн төсвийг Сүмбэр сумаас бусад 26 суманд нийт 4428.5 сая төгрөг зарцуулахаар батласан байна.

2017 оны хувьд аймгийн хэмжээнд 3 дугаар улирлын байдлаар 24 суманд 380 төслийг хэрэгжүүлэхээр 2066.8 сая төгрөгийн зээлийг олгосон ба Сүмбэр, Цээл, Дэлгэрхаан сумдад зээл огт олгогдоогүй байна.

СХСХБЗТХТЖ-ын 3.3.1-д сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох гэж заасны дагуу Баянчандмань сум 30.0 сая төгрөгөөр, Зуунмод сум 40.0 сая төгрөгөөр, Лүн, Алтанбулаг сумд 50.0 сая төгрөгөөр бусад сумд 10.0-20.0 сая төгрөгөөр тус тус тогтоосон ба Баянхангай, Баянцагаан, Заамар, Баян-Өнжүүл, Баянжаргалан зэрэг 6 сум тогтоогоогүй байна.

2017 оны 3-р улирлын байдлаар харуулбал:

№	Сумын нэр	ИТХ-аар батлуулсан байдал	/ мянган төгрөгөөр/ 2017 оны эхний 9 сарын байдлаар олгосон зээл				
			сангаас олгох зээлийн төсөв	нэг төсөлд олгох дээд хэмжээ	Төслийн тоо	Зээлийн дүн	нэг төсөлд олгосон дээд хэмжээ
1	Алтанбулаг		256,000.0	50,000.0	17	225,000.0	50,000.0
2	Аргалант сум		220,000.0	20,000.0	20	133,500.0	10,000.0
3	Архуст сум		150,000.0	10,000.0	32	117,300.0	10,000.0
4	Батсүмбэр		153,000.0	25,000.0	9	89,500.0	15,000.0
5	Баяжаргалан		88,000.0	-	8	56,000.0	10,000.0
6	Баян		192,000.0	20,000.0	10	95,500.0	15,000.0
7	Баяндэлгэр		252,000.0	20,000.0	23	95,300.0	15,000.0
8	Баян-өнжүүл		230,000.0	-	4	42,000.0	19,500.0
9	Баянхангай		75,000.0	-	2	9,500.0	8,000.0
10	Баянцагаан		140,000.0	-	30	105,000.0	6,000.0
11	Баянцогт сум		136,700.0	20,000.0	23	62,750.0	6,000.0
12	Баянчандмань		251,654.7	30,000.0	15	80,300.0	11,000.0
13	Борнуур		180,000.0	20,000.0	11	33,100.0	5,000.00
14	Бүрэн		189,500.0	15,000.0	27	126,300.0	10,000.0
15	Дэлгэрхаан		185,678.0	20,000		-	20,000.0
16	Жаргалант		250,000.0	20,000.0	19	101,500.0	13,000.0
17	Заамар		167,000.0	-	21	82,610.0	10,000.0
18	Зуунмод сум		400,000.0	40,000.0	34	214,000.0	25,000.0
19	Лүн		120,000.0	20,000.0	4	60,500.0	10,000.0

20	Мөнгөнморьт	140,000.0	20,000.0	18	78,350.0	12,500.0
21	Өндөрширээт	150,000.0	20,000.0	18	78,350.0	9,300.0
22	Сүмбэр	-	20,000.0	-	-	-
23	Сэргэлэн	60,000.0	20,000.0	6	7,938.0	1,323.0
24	Угтаалцайдам	100,000.0	20,000	7	58,000.0	20,000.0
25	Цээл	98,000.0	20,000.0	-	-	-
26	Эрдэнэ	89,000.0	10,000.0	12	42,500.0	5,000.00
27	Эрдэнэсант	155,000.0	20,000.0	10	72,000.0	20,000.0
Нийт дүн		4,428,532.7		380	2,066,798.0	

Хүснэгтээс 2017 оны эхний 9 сарын байдлаар нэг төсөлд олгосон зээлийн дээд хэмжээг тогтоосон дүнтэй харьцуулахад зээл олгосон 24 сумаас 7 сум нь харьцангуй багаар буюу дээд хэмжээг 5.0-8.0 сая төгрөгөөр олгосон ба 11 сум 10.0-15.0 сая төгрөг, 4 сум 20.0 сая төгрөг, 1 сум 25.0 сая төгрөг, 1 сум 40.0 сая төгрөг, 1 сум 50.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх ЖДҮ эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь СХСХБЗТХТЖ-ын 4.2.1-4.2.4-д заасан шаардлагыг хангаж буй эсэхийг хянан шийдвэрлээгүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор болон 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам” –аар сангийн хөрөнгийг сумдад ЖДҮ шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна гэж заасан.

СХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг журмын 3.3.3-д заасны дагуу сумдын ИТХ-аас байгуулсан төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл нь сонгон шалгаруулж, сумын Засаг дарга нь шалгарсан төслийг захирамжлан гэрээ байгуулан олгосон байна.

2014-2016 онд сангаас олгосон зээлийн гэрээг сумын Засаг дарга, мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн, халамжийн байцаагч, нягтлан бодогч нар зээлдэгч болон хамтран зээлдэгчтэй байгуулсан ба зарим сумд нь наториатаар батлуулаагүй байна.

Аудитын явцад 27 сумын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг хэрхэн явуулж байгаатай танилцахад төслийг цөөн хэдэн сумд төслийг нэг бүрчлэн хэлэлцдэг ба ихэнх сумд төслийг хэлэлцдэггүй, зөвлөлийн гишүүд хуралд бүрэн оролцдоггүй, хурлын тэмдэглэл, шийдвэрийг гарын үсгээр баталгаажуулдаггүй, сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд болон зээл хэрэгжүүлэх төсөл нь журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг хянадаггүй, ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргадаггүй байна.

СХС-гаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх ЖДҮ эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь СХСХБЗТХТЖ-ын 4.2.1-4.2.4-д заасан шаардлагыг зөрчиж сангаас зээл олгосон байна. Тухайлбал:

СХСХБЗТХТЖ-ын 4.2.1-д “тухайн суманд бүртгэлтэй буюу байнга оршин сууж үйл ажиллагаа явуулдаг байх” гэсэн шаардлага зарим сумдад зөрчигдсөн байна.

- Дэлгэрхаан сум нь 2015 онд УБ хотын харьяалалтай иргэн Нарандуламд ахуй үйлчилгээний зориулалтаар 10.0 сая төгрөг, 16.2 сая төгрөгийн тоног

төхөөрөмжийг олгосон. Бусад банкинд өргүй гэдэг тодохойлолтыг зөвхөн сумынхаа банкнаас тус тооцооны төвд өргүй гэсэн тодорхойлолтыг хавсаргасан байна.

- Эрдэнэ сум нь Зуунмод сумын харьяат Ю.Бямбацогтод 5.0 сая төгрөг олгож зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байна. .

СХСХБЗТХТЖ-ын 4.2.2-д “сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” гэж заасан шаардлагыг харгалзаагүй оновчтой биш шалгаруулснаас зээлийн хугацаа хэтрэлт нэмэгдэж байна. Тухайлбал

- Дэлгэрхаан сум нь өмнөх зээлийн 6.0 сая төгрөгийн өртэй Есөн-Эрдэнэ хоршоонд үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулж 5.0 сая төгрөгийн зээлийг нэмж олгосон
- Баянцагаан сум нь 2017 онд 30 иргэн аж аж ахуйн нэгж байгууллагад зээл олгохдоо малчны зээлтэй 8 иргэнд, цалингийн зээлтэй 1 иргэнд, өрхийн зээлтэй 1 иргэнд олгосон
- Баян сум нь иргэн Г.Цэрэндэжид 2014.05.20-нд 10.0 сая төгрөгийн зээл авахад хамтран зээлдэгчээр зээл авсан Г.Дүгэрлхамд 2014.12.26-нд мөн 10.0 сая төгрөгийн зээлийг олгосон. 2017 оны 09-р сарын байдлаар Г.Цэрэндэжид 4.1 сая төгрөг, Г.Дүгэрлхам 4.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Цээл сум Б.Оюунэрдэнэд 2013 онд граш барихад 1.5 сая төгрөг олгосноос 0.8 сая төгрөгийг төлөөгүй байхад 2015 онд блокны машин авахад 3.0 сая төгрөгийг нэмж олгосон одоо болтол зээлийг төлөөгүй 4.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна
- Цээл сум Н.Мөнхсайханд 2013 онд 5.0 сая төгрөгийн зээл олгосноос 1.4 сая төгрөгийг төлөөгүй байхад 2015 онд 3.0 сая төгрөгийг нэмж олгосон. Дээрх 2 зээлийг төлөөгүй байхад 11.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн зээлийг олгосон нь төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн байна.
- Алтанбулаг сум нь 2017 онд Хустай мандал хоршооны эзэн М.Нямсүрэнд мал нядалгааны газар байгуулах зориулалтаар 50.0 сая төгрөгийг олгосон. М.Нямсүрэн нь төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн гишүүн ба өмнө нь 2015.08.12-нд өвс бэлтгэхээр 2 сарын хугацаатай авсан 20.0 сая төгрөгийн зээлийг бүрэн төлөөгүй 2.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, хүү, алданги огт төлөөгүй тооцоогүй байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.2.3-д “зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх” гэж заасны дагуу барьцаа хөрөнгийн гэрээ байгуулаагүй, барьцаа байхгүй, барьцаанд тавьсан хөрөнгийн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар аваагүй нийтлэг зөрчил байна.

- Жаргалант, Баянчандмань, Сэргэлэн сумдаас бусад сумд барьцааны хөрөнгийг эх хувиар нь авч хадгалахгүй байна.
- Баянцагаан сум 2015 онд мал, гэр 2017 онд мал, бууц, өвөлжөө, хаваржаа, өмчлөлийн газрыг барьцаалсан ба гэрчилгээг огт хавсаргаагүй байна. Бууц гэж юуг барьцаалсан нь ойлгомжгүй ямар ч баримт байхгүй байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.2.4-д “жижиг дунд үйлдвэр эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх” гэсэн шалгуурыг хангаж буйг мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ, сертификат зэрэг нотлох баримт бичгийг зарим сумд хуулбарыг канондаж хавсаргасан ба ихэнх сумдад огт байхгүй байна.

Сангаас зээл хүссэн иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл нь СХСХБЗТХТЖ-ын 4.3.1-4.3.6-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг хянан шийдвэрлээгүй байна.

2014-2017 онд сангаас зээл хэрэгжүүлсэн төсөл нь зах зээлийн судалгаагүй, зээлийн эргэн төлөлтийн графикгүй, зээлийн гэрээнээс зөрүүтэй, орлогын зардлын тооцоог бодит төлөвлөөгүй, зээлийг хэрэгжүүлснээр хэдэн ажлын байр бий болгох нь тодорхойгүй, зээл хүсэгчийн төсөл нь эдийн засгийн болон маркетингийн судалгаа тооцоогүй, зарим зээл бичигдсэн төсөлгүй байна. Тухайлбал:

- Борнуур сум нь 2014 онд 43 иргэнд нийт 69.2 сая төгрөгийн зээлийг, нэг төсөлд 1.0-1.7 сая төгрөгийг олгосон. Зээлийг төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдааны шийдвэргүйгээр Засаг дарга захирамж гарган, Засаг дарга өөрөө зээлийн гэрээ хийж олгосон. Дээрх 43 иргэнд олгосон зээлээс 18 нь төсөлтэй, 25 нь огт бичигдсэн төсөлгүй ба банкны лавлагаа байхгүй, барьцаа хөрөнгө байхгүй, хамтран зээлдэгчгүйгээр олгосон байна
- Баянчандмань сум 2017 онд Ч.Авирмэд хүлэмжийн аж ахуй эрхлэх 3.0 сая төгрөгийн төсөл бичиж, сум хөгжүүлэх сангаас 2.0 сая төгрөг олгохыг хүссэн өргөдөл бичсэн байна. Гэтэл СХСангийн 2017.06.30 ны 4-р хуралдаанаар төслийг хэлэлцэн гантай байгаа учраас энэ жил ногоон тэжээл тариалахаар шийдээд 112 га-д тарьсан. Аймгийн Засаг даргын захирамжаар 100 тн өвс, 50 тн тэжээл бэлтгэх даалгавартай. СХС-аас 9.0 сая төгрөгийг Авирмэдийн нэрээр гаргаж төлөлтийг ЗДТГ өөрсдөө хариуцах юм гээд шийдвэрлэсэн нь 9.0 сая төгрөгийг ЗДТГ хариуцах, 2.0 саяыг Авирмэд хариуцах, нийт 11.0 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэж, сумын Засаг даргын 2017.06.30 ны А/168 тоот захирамжаар иргэн Ч.Авирмэдэд 11.0 сая төгрөгийг олгохоор гарсан. СХС-аас 11.0 сая төгрөгийг иргэн Ч.Авирмэдийн төрийн банкны 310800049050 тоот дансанд шилжүүлсэн зөрчил илэрсэн. ЗДТГ нь 9.0 төгрөгөөр ногоон тэжээл тарьсан. Аудитын явцад тэжээл тариалсан талбайг очиж үзсэн. Зориулалтын дагуу зарцуулаагүй 9.0 сая төгрөгийг Баянчандмань сумын СХС-ийн дансанд 2017 оны 10-р сарын 19-ны өдөр төлбөрийн акт бичиж төвлөрүүлээ.
- Баянцагаан сум 2017 онд сангаас олгосон зээлийг 1 зээлийг төсөлгүйгээр, 1 зээлийг Хөдөлмөр халамжийн газраас малжуулах төслийн хүрээнд хийсэн төсөлд олгосон байна.

Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл нь танил тал, ойр дотны буюу нэгдмэл ашиг сонирхол бүхий хүмүүсээ түлхүү хамруулах, арилжааны банкинд зээлтэй, өрхийн үйлдвэрлэлийг бие даан явуулах бүрэн боломжтой мал бүхий иргэдэд болон зээл хүссэн иргэдийг хавтгайруулан зээлийн хэмжээг бичигдсэн төслөөс харьцангуй бага хэмжээгээр олгож байгаа нь ЖДҮ-ийг хөгжүүлэх гэхээсээ илүү бага хэмжээгээр олон иргэнд олгож иргэдийн өдөр тутмын амьжиргаанд буюу арилжааны банкны зээлийг төлөхөд зориулагдаж, сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглахад хүргэж байна. Тухайлбал:

- Баянцагаан сум нь 2015 онд 54 иргэнд 104.9 сая төгрөгийн зээлийг, нэг төсөлд 0.5-2.0 сая төгрөгөөр хавтгайруулан олгосноос 2017 оны 3-р улирлын байдлаар 44.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна.

- Баянжаргалан сум нь 2014 онд иргэн Д.Дагвадоржид 20.0 сая төгрөгийн зээлийн барьцаа хөрөнгөнд малын нас хүйсийг харгалзахгүйгээр 1 толгой адууг 1.0 сая төгрөгөөр, 1 толгой үхрийг 1.2 сая төгрөгөөр, 1 толгой хонийг 0.18 сая төгрөгөөр, 1 толгой ямаа 0.15 сая төгрөгөөр үнэлж зөвхөн малын А дансыг хавсарган олгосон. Уг зээл нь 2017 оны 10-р сарын 01- ны байдлаар нэг ч төгрөг төлөгдөөгүй байна.
- Баян сум нь 2015 онд иргэн Д.Гантөгст малын А дансаар 274 толгой малтай байхад малжуулах төслөөр 5.0 сая төгрөгийг, 2016 онд Д.Батбуян нь малын А дансаар 4256 толгой малтай байхад мал авч зарахад зориулан 20.0 сая төгрөгийг, 2017 онд Батбаатар 262 толгой малтай иргэнд 9.0 сая төгрөгийг гэх мэтээр олгосон байна.
- Баяндэлгэр сум нь 2017 онд иргэн Ш.Ойдовдоржид А дансаар 402 толгой малтай байхад мал худалдан авч борлуулах гэсэн төсөлд 10.0 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатайгаар олгосон байна.
- Архуст сум нэг чиглэлээр олон төсөлд давхардуулан зээл олгож, зээлийг хэт жижиглэн олгож байна. Архуст суманд 2017 онд 31 иргэнд олгосон зээлээс 15 малжуулах төсөлд олгосон. Мөн 2017 онд 12 төрийн албан хаагч болон төсвийн байгууллагын ажилтнуудад зээл олгосон.
- Лүн сум нь Сум хөгжүүлэх сангаас төрийн албан хаагчдад хашаа байшин барих, ахуй нөхцлийг сайжруулах зорилгоор зээл олгосон байна. Мөн төрийн 2 албан хаагчид 14.0 сая төгрөг олгосон байна.
- Аргалант сум 3 албан хаагчдад 10.0 сая төгрөг олгосон байна.

Сумдын төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл нь СХСХБЗТХТЖ-ын 4.3.1-4.3.6-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хэлэлцэн шийдвэрлээгүй нь төслийг зориулалтын дагуу ашиглах, эргэн төлөлт болон орон нутагт ЖДҮ хөгжихөд нөлөөлсөн байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.3.1-д “тухайн суманд ЖДҮ-ийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх” ихэнх сумд төслийг сонгон шалгаруулахдаа энэ шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хэлэлцдэггүй ба сумдад ЖДҮ-ийг хөгжүүлэхэд чиглэгдсэн бодлого байхгүй байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.3.2-д “төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой байх” гэсэн шаардлагыг хангасан эсэхийг шалгахад төслийн үр дүнг ихэнх төсөлд тодорхой тусгадаггүй ба журмын дагуу сангийн хөрөнгийг ЖДҮ-ийг шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж олгоно гэснийг хангаагүй байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.3.3-д “гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх” гэсэн шалгуурыг хангаж ажиллаагүйгээс 2017 оны 3 дугаар улиралын байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн авлага 3806.2 сая төгрөг буюу нийт зээлийн авлагын 49.7 хувийг эзэлж байна. Аудитаар сумдад ажиллах явцад зээлдэгчид нь зээлийн эргэн төлөлтийн графикийг сар бүр төлөхөөр хийдэггүй хугацааны эцэст буюу 2-3 хуваан бөөн төлөхөөр хийж байгаа нь зээлийн эргэн төлөлтөд сөрөгөөр нөлөөлж байна гэсэн тайлбар өгч байлаа.

СХСХБЗТХТЖ-ын 4.3.4-д “төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх” гэсэн шаардлагыг хангаж ажиллах талаар шалгахад ихэнх бичигдсэн төсөлд барьцаалах хөрөнгийн талаар тусгаагүй ба сумд нь барьцаа хөрөнгийн баталгааг арилжааны банк шиг хатуу нөхцөлгүй мал, гэр, өвөлжөө, хаваржааны болон гэр бүлийн хэрэгцээний газрын гэрчилгээ, тээврийн хэрэгслийн

гэрчилгээ зэргийг барьцаалсан. Хөрөнгийг барьцаалахдаа зарим сумд барьцааны гэрээ хийдэггүй, наториатаар батлуулдаггүй, хөрөнгийг үнэлдэггүй, барьцаалсан газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар авдаггүй зэрэг нийтлэг зөрчил байна.

СХСХБЗТХТЖ-ын 4.3.5-д “төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх” гэсэн шалгуур үзүүлэлтийг төсөлд огт тусгадаггүй шаарддаг ч үгүй байна

СХСХБЗТХТЖ-ын 4.3.6-д “ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх” шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч нар нь төсөлд ажлын байрыг нэмэгдүүлнэ, Нийгмийн даатгалын шимтгэл төлнө гэх зэргээр хийсэн боловч аймгийн хэмжээнд сангаас төсөл хэрэгжүүлсэн үр дүнд бий болсон баталгаат ажлын байр ховор байна.

Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна гэсний дагуу зориулалтаар нь зарцуулсан иргэд байгаа хэдий ч, зээлийг аваад төсөл хэрэгжүүлээгүй, төслийн дагуу үйл ажиллагаагаа өргөжүүлээгүй, өөрийн хөрөнгө дутагдалтайгаас үйл ажиллагаа зогсонги байдалтай болж зээл төлөх чадваргүй, хугацаа хэтэрсэн зээлдэгчид дийлэх хувийг эзэлж байна. Иймд төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийн ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 2014-2017 онд СХС-аас зээл санхүүжилт хүссэн 1571 төслийг шалгаруулан 7238.8 сая төгрөгийн зээл олгосон байна

Сум хөгжүүлэх сангаас 2014-2017 оны эхний 9 сарын байдлаар 1571 төсөлд 7238.8 сая төгрөгийн зээлийг олгосон байна. Нийт олгосон зээлийг нэг төсөлд олгосон хэмжээгээр авч үзвэл нэг төсөлд 2.0-5.0 сая төгрөг олгосон зээл нийт зээлийн 44.2 хувийг, нэг төсөлд 2.0 сая хүртэл төгрөг олгосон зээл 31.3 хувийг эзэлж байна. СХС-аас олгогдсон зээл нь олон хүнд хавтгайруулан бичигдсэн төслөөс хэт бага хэмжээгээр олгож төслийг зориулалтын дагуу ашиглахад сөрөг нөлөө үзүүлсэн байна.

№	Зээлийн хэмжээ	Зээлдэгчийн тоо	зээлийн хэмжээ /сая.төг/	Нийт зээлдэгчид эзлэх хувь
1	2.0 сая төгрөг хүртэл	492	699.4	31.3
2	2.0-5.0 сая төгрөг хүртэл	694	2443.8	44.2
3	5.0-10.0 сая төгрөг хүртэл	247	1787.0	15.7
4	10.0-20.0 сая төгрөг хүртэл	113	1593.5	7.2
5	20.0-50.0 сая төгрөг хүртэл	24	655.0	1.5
6	50.0-сая дээш төгрөг	1	60.0	0.1
	Дүн	1571	7238.8	100.0

Аудитын явцад СХС-гаас олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж буй эсэхийг болон зээлийн эргэн төлөлтийг 10 суманд шалгахад төслийн сонгон шалгаруулалт, хяналт шалгалт хийгдсэн байдлаас шалтгаалан харилцан адилгүй хэрэгжилттэй байна. Үүнд:

- Аймгийн хэмжээнд СХС-гаас хамгийн өндөр зээлийг Сэргэлэн сумын иргэн Ц.Батцэнгэлд 2015 оны 5-р сард 60.0 сая төгрөгийг үйлчилгээний төв

байгуулах төсөл хэрэгжүүлэхэд олгосон байна. Зээлийн хэрэгжилтийг үзэхэд үйлчилгээний төв нь 1 давхар байр баригдсан /зээл авахаас өмнө өрлөгийн ажил дууссан байсан/ байна. Үндсэн зээлийн төлөлтийг графикт зааснаас 42.5 сая төгрөгөөр хугацаа хэтэрсэн, 1.91 сая төгрөгийн алдангийг, 0.82 сая төгрөгийн зээлийн хүүг тус тус дутуу тусгасан байв.

- Баянчандмань суманд зээлийн хэмжээ өндөр, хугацаа хэтрэлттэй 10 төслийн хэрэгжилтийг сонгон шалгахад зохих ёсоор хэрэгжиж байлаа
- Борнуур суманд зээл авсан 20 иргэдийг сонгон уулзахад нарийн боов, мал эмнэлэг, хүнсний худалдаа, үнээний ферм гэсэн төслүүд хэрэгжиж бусад төслүүд хэрэгжээгүй байлаа.
- Жаргалант суманд 27 төслийг ажлын байраар нь очиж шалгахад 17 төсөл хэрэгжиж 62.9 хувийн хэрэгжилттэй байв. Жишээ нь нэг багт дугуй засварын зориулалтаар 2 төсөл олгосны хэрэгжилтийг шалгахад 3.0 сая төгрөгийг нэг жилийн хугацаатай авсан иргэн төслөө хэрэгжүүлж байхад, 7.0 сая төгрөгийг 3 жилийн хугацаатай авсан иргэн төслийг хэрэгжүүлээгүй байв.
- Баянхангай суманд 48 зээлдэгчийн 52.1 хувь буюу 25 зээлдэгч нь зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй. Төслийг зориулалтын дагуу ашиглаж байгаа гэсэн 10 зээлдэгчээс 2 төслийг сонгон үзэхэд эзэд нь байхгүй байсан. Нийт зээлээс 2017 онд олгосон 2 зээлээс бусад нь хугацаа хэтэрсэн байна.
- Цээл суманд Т.Бичээгийн гутлын тоног төхөөрөмж түрээслэсэн зээл бүрэн хэрэгжиж 2017 оны нэг сум бүтээгдэхүүнээс алтан медаль хүртсэн, Н.Мөнхсайханы оёдлын төхөөрөмж түрээслэсэн ажлын байранд 2 оёдолчин ажиллаж байсан ба нарийн боовны цех, халуун ус төслийг зориулалтаар ашиглаж байсан. Соёлын төвийн эрхлэгч М.Минжбадгар 11.0 сая төгрөгийг FM радио, урсдаг гэрэл чиглэлээр авсан боловч зээл хэрэгжээгүй урсдаг гэрэл ажиллаж байгаад эвдэрсэн гэсэн тайлбар өгч байсан. Тариа тарих, хадлан, зайрмаг, тариалалт, блок машин зэрэг төслүүд хэрэгжээгүй байсан.
- Сүмбэр сумын 107 зээлдэгчээс 23 зээлдэгчтэй уулзахад тахианы аж ахуй, ахуй үйлчилгээ-оёдол гэсэн 2 төслөөс бусад зээлдэгчийн үйл ажиллагаа хэрэгжээгүй, зориулалт бус олгосон, 3-4 жилээр хугацаа хэтэрсэн байдалтай байсан. 2010 онд олгосон Б.Пүрэвсүрэн, Д.Оюунцэцэг, 2011 онд Д.Үзмээ гэсэн 3 зээлдэгчийн хаяг тодорхойгүйгээс ямар ч төлөлт хийгдээгүй 4.5 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.
- Баянцогт суманд 10 төслийг сонгон үзэхэд 3 төсөл хэрэгжүүлэгч эзэнгүй, 2 зээл зориулалтаар ашиглаагүй, ахуй үйлчилгээний төхөөрөмж түрээслэсэн зээлдэгчтэй уулзахад зээлийг зориулалтаар ашиглахаар бэлтгэл ажлыг хангаж байна гэсэн тайлбартай ажиллаагүй байсан. Талх нарийн боов, Тэжээл үйлдвэрлэх, цацаргана төсөл хэрэгжиж байсан. Мөн аймгийн ХХААГазраас аймагт хүлэмжийн цехтэй болсон түүний үйл ажиллагааг дэмж гэснээр 7 хүлэмж авсан бүгд урагдсан гэсэн санал гомдол гарч байв.
- Батсүмбэр сумын зээлдэгч Д.Энхтуяа 2015 онд адууны мах боловсруулах казны үйлдвэрлэл явуулах чиглэлээр 30.0 сая төгрөгийн зээл авсан. Төсөл эхэн үедээ үйл ажиллагаа хэвийн явагдаж байсан гэх боловч одоогоор үйл ажиллагаа зогсонги байдалтай болсон зээлээсээ төлөлт огт хийгээгүй хугацаа хэтрүүлсэн байна. Д.Ганболд нь Цэцэгт нуга амралтын газарт цахилгаан эх үүсвэр тавих төслөөр 20.0 сая төгрөгийн зээлийг 2014 онд авсан. Амралтын газрын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч зээлээ хугацаанд төлөөгүй 14.6 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байдалтай байна.
- Баяндэлгэр суманд төрсөн ах дүү 2 нэг ажлын байранд 2014 онд 2 жилийн хугацаатай 5.0 сая төгрөг, Нямсүрэн нь 2015 онд 3 жилийн хугацаатай 5.0

сая төгрөг, Нямдорж 2017 онд 3 жилийн хугацаатай 10.0 сая төгрөгийг тус тус худалдаа үйлчилгээ явуулах зориулалтаар нийт 20.0 сая төгрөг авснаас 14.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Иргэн Н.Эрдэнэбат 2013 онд 2 жилийн хугацаатай клонкийн зориулалтаар 10.0 сая төгрөгийн зээл авч хугацаа хэтэрсэн 4 жилийн хугацаанд төсөл хэрэгжээгүй, эзэн холбогдогч хаа яваа нь тодорхойгүй байна. Иргэн Б.Арьяасүрэнд эрчимжсэн мал аж ахуй байгуулах зориулалтаар 2014 онд 2 жилийн хугацаатай 7.0 сая төгрөгийн зээл олгож 2-3 ажлын байр бий болгоно гэсэн хэдий ч зээл огт хэрэгжээгүй, зээлийн эргэн төлөлт байхгүй 8.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Иргэн Д.Адьяад 20.4 сая төгрөгийн ахуй үйлчилгээний зориулалтын тоног төхөөрөмжийг түрээслэх гэрээг 2015 онд хийснээс хойш 0.2 сая төгрөгийн хүү алданги төлснөөс өөр төлөлт хийгдээгүй, нэмж хүү алданги 2.7 сая төгрөг нийт 23.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Мөн ахуй үйлчилгээний тоног төхөөрөмж ажиллуулахад материал авахаар 2015 онд 3 жилийн хугацаатай 5.0 сая төгрөгийн зээл авч, 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй зээлдэгч сумнаас яваад сураггүй болсон байдалтай байна.

Сангаас Засаг даргын захирамжаар олгосон зээлийн дүн, шийдвэр, зээл, зээлийн хүүгийн авлага, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг шилэн дансны сайтад байршуулаагүй байна.

СХС-ийн орлого, зарлагын гүйцэтгэлийг Батсүмбэр, Сүмбэр, Цээл, Өндөрширээт, Жаргалант зэрэг сумд гараар буюу пластик нэгтгэлийн программд шивсэн тайланг хөрвүүлэн гарын үсэг зурж баталгаажуулан гаргадаг ба бусад сумд нь ЗДТГ-ын санхүүгийн программд бааз үүсгэн бүртгэж санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж байна.

Сум хөгжүүлэх сангаас Засаг даргын захирамжаар олгосон зээлийн дүн, шийдвэрийг болон сум хөгжүүлэх сангийн авлага, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг шилэн дансны албан ёсны сайтад ихэнх сумд мэдээлээгүй байна.

СХС-гийн харилцах дансны хуулгыг боловсруулдаггүйгээс зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийг үнэн зөв бүртгэн тайлагнадаггүй, сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн тооцооллыг зөрүүтэй хийдэг, сар улирлаар зээлийн хүүг тооцон бүртгэдэггүй, зээлийн хүүг хугацааны эхэнд бөөн бүртгэх, хугацаа хэтэрсэн зээлийн дүнд гэрээний дагуу алданги тооцдоггүй, зээл, зээлийн хүүгийн авлагыг зөрүүтэй данс бүртгэлд дутуу тусгах зэрэг нийтлэг зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Баянцагаан сум нь 2015 онд 7 иргэнд олгосон 18.5 сая төгрөгийн зээлийг авлагаар бүртгээгүй орхигдуулсан ба 2017 оны санхүүгийн тайланд нэмж өмнөх үеийн үр дүнд бичиж нэмж тайлагнасан гэх боловч аудитад ирүүлсэн судалгаанд оруулаагүй орхигдуулсан байна.
- Баянхангай сум нь 2015 онд 1 иргэнд олгосон 3.0 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй орхигдуулсан ба 2016 оны санхүүгийн тайланд барагдуулсан.
- Дэлгэрхаан сум 2014 онд Дархан хэрлэн ХХК -д ахуй үйлчилгээний тоног төхөөрөмжийн үнэ 15.9 сая төгрөг шилжүүлж, тоног төхөөрөмж хүлээлцсэн актаар 16.2 сая төгрөгийн хөрөнгө авсан боловч зөрүү 0.3 сая төгрөгийг тайлагнаагүй байна
- Баян-Өнжүүл сум нь 15.9 сая төгрөгийн ахуй үйлчилгээний тоног төхөөрөмжийг өнөөдрийг хүртэл түрээслүүлээгүй эргэлтэнд оруулаагүй хөрөнгөнд бүртгэлтэй байна.

2017 оны 3-р улирлын байдлаар Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 577.6 сая төгрөг, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэл 7654.4 сая төгрөг байна.



Аудитад хамрагдсан хугацааны зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдлээр авч үзэхэд 2014 оны жилийн эцсийн байдлаар 5197.7 сая төгрөгийн, 2015 оны жилийн эцсийн байдлаар 6247.4 сая төгрөгийн, 2016 оны жилийн эцсийн байдлаар 5916.6 сая төгрөгийн, 2017 оны жилийн эцсийн байдлаар 7654.4 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Үүнээс харахад 2016 онд зээл, зээлийн хүүгийн авлага өмнөх оноос 330.8 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх онуудад зээл, зээлийн хүү хугацаандаа төлөгдөөгүй эх үүсвэр буурснаас Алтанбулаг, Аргалант, Баянжаргалан, Баянцагаан, Сүмбэр, Дэлгэрхаан, Цээл зэрэг 7 суманд шинээр зээл олгоогүйтэй холбоотой байна.

Аудитын явцад ирүүлсэн 2014-2017 оны сангийн зээл, зээлийн хүүгийн авлагын судалгааг тухайн онуудын санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тулгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Алтанбулаг сумаас ирүүлсэн судалгааны 2016 оны авлагын эхний үлдэгдэл санхүүгийн тайлангийн мөн үеийн үлдэгдлээс 3.1 сая төгрөгөөр жилийн эцсийн авлагын үлдэгдэл 4.6 сая төгрөгөөр зөрүүтэй
- Баянхангай сумаас ирүүлсэн судалгааны 2016 оны авлагын эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн мөн үеийн үлдэгдэл дүнгээс 3.1 сая төгрөгөөр зөрүүтэй
- Бүрэн сумын ирүүлсэн судалгааны 2014 оны жилийн эцсийн зээл, зээлийн хүүгийн авлагын 53 иргэний 257.4 сая төгрөгийн үлдэгдэл нь санхүүгийн тайлангийн аудитлагдсан үлдэгдлээс 1 зээлдэгчийн 1.0 сая төгрөг дутуу ба 38 иргэний зээл 0.01-3.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

- Өндөрширээт сумын зээл, зээлийн хүүгийн авлага 2014 оны эхэнд судалгаагаар 209.9 сая төгрөг байхад 2014 оны санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэл 266.6 сая төгрөг буюу 56.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна
- Зуунмод сумын аудитад ирүүлсэн 2016-2017 оны сум хөгжүүлэх сангийн судалгаа нь тухайн үеийн санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй таарахгүй байна. 2016 оны санхүүгийн тайлан, э-тайлангийн үлдэгдэл 961.6 мянган төгрөг, судалгааны дүн 1167.5 сая төгрөг буюу 205.9 сая төгрөгөөр зөрүүтэй. 2017 оны 3-р улирлын тайланг болон судалгааг засаж ирүүлэхийг аудитын хугацаанд удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй.

СХС-ийн зарцуулалтын 3-р улирлын байдлаарх дэлгэрэнгүй тайланг ХХААЯ-нд хүргүүлээгүй хугацаа хоцруулсан байна.

Сумдын мал эмнэлгийн үржлийн тасгийн дарга мэргэжилтэн нь СХС-ийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг аймгийн ХХААГ-т улирал бүр гарган хүргүүлж, ХХААГ-ын ЖДҮ, хоршоо, ахуй үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн нэгтгэн ХХААЯ-нд хүргүүлэхээр зохицуулагдсан байна.

Аймгийн ХХААГ-ын ЖДҮ, хоршоо, ахуй үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2017 оны эхний 9 сарын байдлаарх сумдын СХС-ийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайлан мэдээг ХХААЯ-нд хүргүүлээгүй хугацаа хоцруулсан байна.

Аудитын явцад сангийн тайланг гаргуулахад 2-3 янзаар зөрүүтэй ирүүлсэн. 2017 оны эхний 9 сарын байдлаар гаргасан СХС-ийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг албажуулан авлаа. Уг тайлангаар 2017 оны 09-р сарын 30-ний байдлаар 6844.6 сая төгрөгийн зээл, зээлийн хүү, алдангийн үлдэгдэлтэй байна.

СХС-ийн сангийн дэлгэрэнгүй тайлангаар аймгийн хэмжээнд 1884 төсөлд 9116.1 сая төгрөг олгосноос хүнсний үйлдвэрлэлийн чиглэлд 180 төсөл буюу 9.6 хувийг, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлд 300 төсөл буюу 15.9 хувийг, газар тариалангийн чиглэлд 262 төсөл буюу 13.9 хувийг, мал аж ахуйн чиглэлд 468 төсөл буюу 24.8 хувийг, барилгын чиглэлд 60 төсөл буюу 3.2 хувийг, худалдааны чиглэлд 170 төсөл буюу 9.0 хувийг, бусад чиглэлд 444 төсөл буюу 23.6 хувийг олгосон байна.

Үйл ажиллагааны чиглэл

Хүнсний үйлдвэр	Хөнгөн үйлдвэр	Газар тариалан	Мал аж ахуй	Барилга	Худалдаа	Бусад	ДҮН
180	300	262	468	60	170	444	1884
9.6	15.9	13.9	24.8	3.2	9.0	23.6	100%

Хүснэгтээс харахад сангийн хөрөнгийг бусад чиглэлд 444 төсөлд олгосон нь нийт төслийн 23.6 хувийг эзэлж байгаагаас зээлийг журмын зорилтод нийцэхгүй төсөлд олгожээ.

Сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн, сум хөгжүүлэх сан хариуцсан нягтлан бодогч нарын ажлын уялдаа холбоогүйгээс 2017 оны 3-р улирлын байдлаарх ХХААГ-ын гаргасан СХС-ийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайлангийн зээл, зээлийн хүү, алдангийн үлдэгдэл 6844.6 сая төгрөг, санхүүгийн

тайлангийн авлага 7654.4 сая төгрөг буюу 809.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. СХС-гийн зээлийн авлагын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

2017 оны эхний 9 сарын байдлаарх авлагын үлдэгдлийг ХХААГ-ын сангийн дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэлтэй харьцуулбал: /мянган төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2017 оны эхний 9 сар				ХХААГ-ын тайлангийн үлдэгдэл	Зөрүү /СТ- аас +дутуу -илүү/
		ОНЫ ЭХНИЙ		ОНЫ ЭЦСИЙН			
		Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Алтанбулаг	37	121329.8	40	285436.6	233100.0	52336.6
2	Аргалант	74	194229.6	76	287350.6	290115.6	-2765.0
3	Архуст	92	250987.2	113	309568.7	272410.2	37158.5
4	Батсүмбэр	18	250596.6	24	256447.1	255744.8	702.3
5	Баян	31	213558.8	34	252933.2	241385.9	11547.3
6	Баяндэлгэр	185	209749.5	92	246738.1	246738.1	0.0
7	Баянжаргалан	19	194442.4	24	226693.1	246222.5	-19529.4
8	Баянөнжүүл	43	234052.8	45	244419	251635.4	-7216.4
9	Баянхангай	46	184999.9	46	181600.9	182255.6	-654.7
10	Баянцагаан	95	173835.8	94	206805.3	216840.1	-10034.8
11	Баянцогт	74	255951.9	61	271678.6	275180.4	-3501.8
12	Баянчандмань	58	307305.5	52	306169.7	227082.0	79087.7
13	Борнуур	172	245603.5	159	245751.1	248420.5	-2669.4
14	Бүрэн	52	253103.7	67	298618.2	285373.6	13244.6
15	Дэлгэрхаан	54	270653.8	54	254796.8	227123.3	27673.5
16	Жаргалант	90	309924.6	86	339700	333101.1	6598.9
17	Заамар	90	323739.2	84	302760	324200.4	-21440.4
18	Лүн	58	219177.9	58	243753.7	206061.2	37692.5
19	Мөнгөнморьт	64	248340.8	70	277408.6	208996.4	68412.2
20	Өндөрширээт	46	238579.4	42	221862.2	106969.3	114892.9
21	Сэргэлэн	49	298376.2	57	287244.4	219122.8	68121.6
22	Сүмбэр	95	233532.6	92	207837.6	216532.2	-8694.6
23	Угтаал	50	270496.7	48	269490.8	226860.4	42630.4
24	Цээл	63	219031.3	61	201649.8	205151.6	-3501.8
25	Эрдэнэ	86	246906.2	88	274706.8	192151.7	82555.1
26	Эрдэнэсант	68	204109.6	71	242054.4	243579.9	-1525.46
27	Зуунмод	193	961651.9	180	910880	662224.3	248655.7
	НИЙТ ДҮН	2002	7134267	1918	7654355	6844579.3	809776.0

Хүснэгтээс Баяндэлгэр сумаас бусад сумд 0.6 -248.6 сая төгрөгийн зөрүүтэй байна. Тухайлбал хамгийн их зөрүүтэй нь Зуунмод сум 248.6 сая төгрөг, Өндөрширээт сум 114.9 сая төгрөг, Эрдэнэ сум 82.5 сая төгрөг, Баянчандмань сум 79.1 сая төгрөг, Мөнгөнморьт сум 68.4 сая төгрөг байна.

Асуудал 3

СХС-гийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалт үр дүн муутай байна

Сангаас төсөл хэрэгжүүлсэн үр дүнд баталгаатай ажлын байр бий болж чадахгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр шинээр болон байнгын ажлын байрыг нэмэгдүүлсэн эсэхийг судалгааны маягтаар нэгтгэн авч үзэхэд 2017 оны эхний 9 сарын байдлаар 380 төсөл хэрэгжүүлсэн ба зээл хүссэн төсөлд 293 ажлын байр бий болгохоос 108 ажлын байр буюу 36.9 хувьд нь ажлын байр бий болгосон байна.

СХС-гаас зээл олгох төслийг сонгон шалгаруулахдаа ажлын байр нэмэгдүүлэх шалгуур үзүүлэлтийг хянан хэлэлцдэггүйгээс зарим төсөлд ажлын байрны талаар тусгадаггүй, зарим төсөл хэрэгжүүлэгч нар нь төсөлд ажлын байрыг нэмэгдүүлнэ, нийгмийн даатгалын шимтгэл төлнө гэх зэргээр хийсэн боловч хэрэгжүүлдэггүй, ажлын байр бий болгох төслийн хэрэгжилтэнд хяналт тавьдаггүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал байна.

СХС-гаас зээл авснаар шинээр бий болгосон ажлын байрны судалгааг Баянцагаан, Лүн, Дэлгэрхаан, Борнуур, Угтаал, Цээл, Эрдэнэ, Мөнгөнморьт зэрэг 8 сум аудитын явцад ирүүлээгүй нь сангаас төсөл хэрэгжүүлснээр баталгаат ажлын байр бий болдоггүйг нотлож байна.

ХХААГ-аас ирүүлсэн СХСангийн 3-р улирлын хураангуй тайлангаар зээл авахыг хүссэн төслөөр 578 ажлын байр бий болгохоос 1142 ажлын байр бий болгосон гэж тайлагнасан нь Татвар, Нийгмийн даатгалын байцаагчийн зээл авсан иргэдийн шимтгэл татварт хамрагдсан судалгаагаар нотлогдохгүй байна. Энэ нь төслийн үр дүнд бий болсон ажлын байрыг үнэн зөв бодитой тайлагнахгүй байна. 2017 онд сангаас олгосон зээлийн үр дүнгээр бий болсон ажлын байрны судалгаа

№	сумдын нэрс	Зээл авсан Төслийн тоо	Аудитад ирүүлсэн судалгаагаар		ХХААГазрын тайлангаар	
			төлөвлөсөн ажлын байр	бий болгосон ажлын байр	төлөвлөсөн ажлын байр	бий болгосон ажлын байр
1	Алтанбулаг	17	7	15		15
2	Аргалант	20	18	0		20
3	Архуст	32	19			24
4	Батсүмбэр	9	7	0	4	3
5	Баян	8	11		29	15
6	Баяндэлгэр	10	6	1		21
7	Баянжаргалан	23	15		10	0
8	Баянөнжүүл	4	3	1		7
9	Баянхангай	2	3	4		2
10	Баянцагаан	30			32	19
11	Баянцогт	23	25			3
12	Баянчандмань	15	29	5	1	0
13	Борнуур	11			164	11
14	Бүрэн	27	20	8	24	7
15	Дэлгэрхаан				33	0
16	Жаргалант	19	19	19	40	15
17	Заамар	21	37	7	97	20
18	Лүн	34		14	10	2

19	Мөнгөнморьт	4			1	0
20	Өндөрширээт	18	6	6		0
21	Сэргэлэн	18	12	1	19	6
22	Сүмбэр	-				0
23	Угтаал	6			20	0
24	Цээл	7			30	0
25	Эрдэнэ	-			14	5
26	Эрдэнэсант	12	22	10	7	0
27	Зуунмод	10	34	17	43	35
	НИЙТ ДҮН	380	293	108	578	230

Аймгийн Засаг даргын “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах” 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих ажил хангалтгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам" –ын хэрэгжилт, сангийн удирдлага зохион байгуулалт, зээлийн зарцуулалт, хяналт хангалтгүйгээс сангийн эх үүсвэрийн 47 хувь нь хугацаа хэтэрсэн, зээлийн өр авлага үүссэн, зээлийг зориулалтын дагуу ашигладаггүй зэрэг зөрчлүүдийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдөр “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах”-аар гаргажээ.

Албан даалгаварын хүрээнд 2017 оны 03-р сарын 15-наас 04-р сарын 15-ний хооронд сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтрэлттэй зээлийг барагдуулах сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулахаар сумдад чиглэл өгөгдсөн байна.

Албан даалгаварт хэрэгжилтийг ханган, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-нд гарган аймгийн ХХААГ-т ирүүлж байхаар заасны дагуу 1-р улирлын хэрэгжилтийг гаргаж, 2.3-р улирлын хэрэгжилтийг гараагүй байна. Албан даалгаврын хэрэгжилтэнд Баян-Өнжүүл, Баян, Баянчандмань, Зуунмод, Бүрэн зэрэг 5 сум тайланг хугацаандаа ирүүлсэн бусад сумд хугацаанд нь ирүүлээгүй гэсэн нь хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Албан даалгаврыг хэрэгжүүлэх талаар сумд нь тодорхой үр дүнд хүрсэн ажлыг зохион байгуулаагүй байна.

ХХААГ-аас сумдын Мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэнгүүдийн чадавхжуулах сургалтаар “СХС-ийн хувийн хэргийг хэрхэн бүрдүүлэх” талаар чиглэл өгөгджээ.

Аймгийн хэмжээнд ихэнх сумдын мал эмнэлэг үржлийн тасгийн мэргэжилтэн нь ажил үүргийн дагуу СХС-гаас олгосон зээлийн хувийн хэргийн бүрдүүлэлт, зээл олголт, зээлийн эргэн төлөлт, зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаад хяналт тавьж ажиллахгүй байна. Иймээс хувийн хэргийн бүрдүүлэлт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт хангалтгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан СХСХБЗТХТЖ-ын 3.3-д Сангийн үйл ажиллагааны талаар сумын ИТХ-ын хэрэгжүүлэх чиг үүргийг заасан. Сумдын ИТХурал нь шинэ журмыг хэрэгжүүлэн сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг болон сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг шинэчлэн байгуулсан байна.

Сумдын нэрс	ИТХ-аар Төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын зөвлөлийг батлуулсан байдал тавих
Алтанбулаг	2016 оны 11-р сарын 28 -ны ИТХ-ын тогтоол №66
Аргалант	2016 оны 12 -р сарын 19 -ны ИТХ-ын тогтоол № 08
Архуст	2016 оны 12 -р сарын 12 -ны ИТХ-ын тогтоол № 03
Батсүмбэр	2017 оны 04 -р сарын 05-ны ИТХ-ын тогтоол № 50
Баян	2017 оны 03 -р сарын 14 -ны ИТХ-ын тогтоол № 15
Баяндэлгэр	2017 оны 01 -р сарын 02 -ны ИТХ-ын тогтоол № 03
Баянжаргалан	2017 оны 01 -р сарын 25 -ны ИТХ-ын тогтоол № 25
Баянөнжүүл	2016 оны 12 -р сарын 15 -ны ИТХ-ын тогтоол № 11
Баянхангай	2016 оны 12 -р сарын 16 -ны ИТХ-ын тогтоол № 12
Баянцагаан	2017 оны 04 -р сарын 14 -ны ИТХ-ын тогтоол № 29
Баянцогт	2017 оны 04 -р сарын 25 -ны ИТХ-ын тогтоол № 28
Баянчандмань	2017 оны 05 -р сарын 03 -ны ИТХ-ын тогтоол № 03
Борнуур	2017 оны 07-р сарын 28-ны ИТХ-ын тогтоол №07,08
Бүрэн	2016 оны 12 -р сарын 13 -ны ИТХ-ын тогтоол № 31,32
Дэлгэрхаан	2017 оны 04-р сарын 20-ны ИТХ-ын тогтоол № 11.12
Жаргалант	2017 оны 01 -р сарын 27 -ны ИТХ-ын тогтоол № 07
Заамар	2017 оны 04 -р сарын 13 -ны ИТХ-ын тогтоол № 29
Зуунмод	2017.04.26-ны ИТХ-ын Төлөөлөгчдийн тогтоол №05
Лүн	2016 оны 12 -р сарын 12 -ны ИТХ-ын тогтоол № 12,13
Мөнгөнморьт	2013 оны 04 -р сарын 24 -ны ИТХ-ын тогтоол № 24
Өндөрширээт	2017 оны 06 -р сарын 09 -ны ИТХ-ын тогтоол № 40
Сүмбэр	2017 оны 07-р сарын 02- ны ИТХ-ын тогтоол №04
Сэргэлэн	2017 оны 03 -р сарын 24 -ны ИТХ-ын тогтоол №23, 29
Угтаал	2017 оны 04 -р сарын 13 -ны ИТХ-ын тогтоол № 03
Цээл	2017 оны 06 -р сарын 09 -ны ИТХ-ын тогтоол № 05
Эрдэнэ	2017 оны 02 -р сарын 10 -ны ИТХ-ын тогтоол № 24
Эрдэнэсант	2017 оны 01 -р сарын 03 -ны ИТХ-ын тогтоол № 03

СХСХБЗТХТЖ-ын 3.1-д сумын ИТХ нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт шалгалт хийх орон тооны бус ажлын хэсгийг байгуулна, журмын 5.3-д ажлын хэсэг нь тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна гэж заасны дагуу зохих ёсоор хэрэгжүүлэн ажилласан ч үр дүн муутай байна.

Сумын ИТХ-аар баталсан орон тооны бус зөвлөл байгуулсан боловч ихэнх сумдын зөвлөл нь СХС-гийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт шалгалт хийхгүй байна. СХС-аас авсан зээлийг хугацаанд нь төлөхгүй, урсгалаар явж байна. Ер нь нэхэж шахдаг хүн ч ховор, нягтлан бодогч нар орсон мөнгийг тооцож бүртгэж байгааг сумдын удирдлагууд анхаарч ажиллах цаг нь болсон байна. Сумдын хэрэгжүүлсэн хяналт шалгалтаас үзэхэд:

- Жаргалант сумын хяналт шалгалт явуулах ажлын хэсэг нь 2014 онд хяналтын шалгалт хийж 56 иргэний зээлийн ашиглалт, зориулалт, эргэн төлөлт, ажлын байр нэмэгдүүлсэн байдал, зээлийн үр дүнгийн талаар нэг бүрчлэн танилцаж ажилласан байна. Нийт зээлдэгчийн 52.0 хувь нь хугацаандаа төлж байна гээд зээлийн талаар дүгнэлт гаргасан байна. 2015 онд хугацаа хэтэрсэн 4 иргэний материалыг шүүхэд өгөхөөр шийдвэрлэсэн. СХС-гийн хугацаа хэтэрсэн зээлтэй иргэдэд шаардах мэдэгдэл хүргүүлэхээр шийдвэрлэсэн. 2016, 2017 онд хяналт шалгалт явуулах Зөвлөл нь тодорхой ажил хийгээгүй байна.
- Баян сумын СХС-гийн хяналт шалгалт явуулах ажлын хэсгийн 2014 онд хийсэн шалгалтын дүнгээр 40-өөд хувь нь зориулалтаар ашиглаж байгаа. 5 айл огт юу ч хийгээгүй байна. Зээлийн гэрээнд зээлийг зориулалт бусаар ашиглавал зээлийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж үндсэн зээлийг

эргэн төвлөрүүлж хүүг арилжааны хүүгээр бодож авна гэсэн заалт оруулсан боловч хэрэгжүүлээгүй байна.

- Баянчандмань сумын СХС-гийн зээл хариуцсан мэргэжилтэн нь хугацаа хэтэрсэн зээлийн түүхийг хөтлөж зээлдэгч бүртэй уулзсан, мэдэгдэл өгсөн мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэдэг байна. Зээлийн төлбөрийг хугацаандаа төлж байгаа ч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй 2 зээлдэгчийг төслийн мөнгийг эргэн татахаар 2016 онд шүүхэд шилжүүлсэн байна.
- Өндөрширээт сумын СХС-гийн хяналтын зөвлөл нь 2014-2017 онд хяналт шалгалт хийгээгүй байна.
- Бүрэн сум нь СХС-гийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хийх хяналт шалгалтыг жил бүр үр дүнтэй хэрэгжүүлснээр хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт бусад сумдуудтай харьцуулахад харьцангуй бага байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. СХС-гаас олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, 2017 оны эхний 9 сарын байдлаар хугацаа хэтэрсэн зээл 3806.2 сая төгрөг буюу нийт зээлийн 49.7 хувьтай тэнцэж байна.
2. Хугацаа хэтэрсэн зээл, авлагын талаар Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах талаар ажил зохион байгуулаагүй байна.
3. ММСС-аас малчдын бүлэгтэй байгуулсан худаг гаргах гэрээний дагуу санд төвлөрөх 138.1 сая төгрөг, зээлийн хүүг дутуу тооцон 84.2 сая төгрөг нийт 222.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.
4. Аймгийн Засаг даргын “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах” 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих ажил хангалтгүй байна.
5. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төслийг СХСХБЗТХТЖ-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг хянаж шийдвэрлээгүй байна.
6. СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хийгдсэн хяналт шалгалт үр дүн муутай байна
7. СХС-гаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд байнгын ажлын байр бий болоогүй байна.
8. 2017 оны 3-р улирлын байдлаарх ХХААГ-ын гаргасан СХС-гийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайлангийн зээл, зээлийн хүү, алдангийн үлдэгдэл 6844.6 сая төгрөг, санхүүгийн тайлангийн авлага 7654.4 сая төгрөг буюу 809.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, ХХААГ-ын дарга Б.Жамбалдорж нарт ЗӨВЛӨХ НЬ:

1. СХС-гаас олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээлийн санд оруулах ажлыг зохион байгуулах
2. Аймгийн Засаг даргын “Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сайжруулах” 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэнд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах
3. Сангаас олгох зээлийн төсөлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан зээлдэгчийг сонгон шалгаруулж ажлын байр бий болгоход анхаарч ажиллах
4. Зээлийн гэрээний дагуу хүү, алдангийг үнэн зөв тооцон бүртгэж тайлагнах
5. СХС-гийн зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг анхан шатны баримтанд тулгуурлан батлагдсан маягтын дагуу бүрэн гүйцэт үнэн зөв гаргуулан авч, нэгтгэлийг СТСХ-т ирүүлж зээлийн авлагын зөрүүг арилгаж ажиллах

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

Ц.БАЗАРСАД

АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

О.СОСОР

Ж.БЯМБАЦОГТ

А.БАТЛХАВГА

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


ТӨВ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
41100 Зуунмод сум, Төв аймаг
Утас/факс: 70273092

2017.11.22 № 569
танай _____-ны _____-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт зөвлөмжтэй танилцлаа.

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА  Б. ЖАМБАЛДОРЖ



НННННННН: Албан бичиг: тоот А5